

## ШАРЫН ГОЛЫН УРСАЦЫН ГОРИМЫН ӨӨРЧЛӨЛТ, БОХИРДОЛ

Шарын голын ус судлалын Шарын гол –Жимс ногоо харуулын ажиглалтын материалаар ус хурах талбай  $2839 \text{ км}^2$ , олон жилийн дундаж урсацын модуль  $0.72 \text{ л/с км}^2$ , өнгөрөлт  $2.24 \text{ м}^3/\text{с}$  тус тус байна. Шарын гол –Жимс ногоо харуулын урсацын олон жилийн хувьсал өөрчлөлтөөс үзэхэд 1970-аад оны сүүл, 1980-аад оны дунд, 2000-аад оны эхэн, 90-ээд оны эхэн үед ус элбэгтэй услаг жилүүд, харин 1960 оны дунд, 70 оны сүүлээс 80-аад оны эхэн болон 90 оны дунд үеэс одоог хүртэл татруу устай байна.

Голын урсацын жилийн доторх хуваарилалт жигд бус жилийн урсацын хуваарилалтын 80 хувь нь хавар зуны улиралд /4-9 сар/, 10 хувь нь намар өвлийн улиралд /10-3 сар/, 8 хувь нь намрын улиралд /10-11 сар/, 2.5 хувь нь өвлийн улиралд /12-3 сар/ тус тус ногдоно. Голын услагаас үл хамааран урсацын дийлэнх хувь нь дулааны улиралд ноогддог. Элбэг устай байсан 2010 онд жилийн урсацын 40 орчим хувь 6-р сард ногдож байна. Бага устай байсан 1999 онд жилийн урсацын 50 хувь нь 7,8-р сард ногдож байна.

Шарын голын уртын дагууд Шарын голын эх, Шарын голын мониторингийн цэг, Шарын гол Хүйтний голтой нийлсний дараа, Шарын голын адагт зэрэг нийт 7 цэгт 2019 оноос эхлэн 2020 оны 7 сар хүртэл 4 удаагийн давтамжтай ус зүйн хэмжилт хийсэн. Шарын голын хувьд уртын дагууд уурхайн нөлөөллөөс голын ус булингар ихтэй, голын эхэнд хэсэгтээ Шарын гол сумын нутагт үйл ажиллагаагаа явуулж буй алтны уурхайдын нөлөө маш их голын гулдрилыг өөрчилсөн, гулдрилд нь уурхайн нөлөөгөөр үүссэн нуур цөөрөм маш ихтэй, эргийн дагуух мод ургамалгүй болсон, маш их шороон овоолго үүсгэж орхисон байдалтай байна.




Шарын голд ус зүйн хэмжилт хийсэн хөндлүүр



Шарын голын уурхайн нөлөөгөөр голын гулдрил өөрчлөгдсөн байдал

### Шарын голын уртын дагуух цэгүүдэд хийсэн урсац болон булингарын хэмжилт

Д/д	Хэмжилт хийсэн хөндлүүр	2019 оны 5-р сар		2019 оны 10-р сар		2020 оны 5-р сар		2020 оны 7-р сар	
		Урсац, м <sup>3</sup> /с	Булингар, NTU	Урсац, м <sup>3</sup> /с	Булингар, NTU	Урсац, м <sup>3</sup> /с	Булингар, NTU	Урсац, м <sup>3</sup> /с	Булингар, NTU
1	Шарын гол эх	0.418	18.50	0.137	2.3	0.338	3.28	0.12	7.51
2	Шарын голын эх гүүрний доор	0.439	11.97			0.380	21.9	0.33	11.46
3	Шарын гол Мониторингийн цэг	0.280	45.95	0.092	5.24	0.385	23.9	0.76	15.82
4	Шарын гол, Аргал уул	0.314	41.68		23.06	0.265	22.3	0.23	72.0
5	Шарын гол (Хүйтний голтой нийлэхийн өмнө)	0.337	185.40	0.203	49.84	0.158	53.2	1.19	169
6	Хүйтний гол, Шарын гол нийлсний дараа	1.030	153.20	0.760	64	0.828	29.6	1.46	137
7	Шарын голын адаг	0.632	157.07	0.549	21.96	0.256	87.4	1.006	156



Шарын голын уртын дагуух урсацын өөрчлөлт /2019-2020/

Шарын голын урсацын өөрчлөлтөөс харахад Шарын голын эхээс Шарын голын мониторингийн цэг хүртэл урсац нэмэгдэн 0.28-0.76 м<sup>3</sup>/с, голын дунд хэсэг болох Шарын голын Аргал уулын харалдаа цэгт урсац алдагдан 0.23-0.31 м<sup>3</sup>/с, Шарын голын томоохон цутгал болох Хүйтний голтой нийлснээс доош урсац нэмэгдэн 0.76-1.46 м<sup>3</sup>/с, голын адаг хүрэхэд буюу Орхон голтой нийлэхийн өмнө урсац багасан 0.26-1.01 м<sup>3</sup>/с хүрдэг байна.

Шарын голын булингарын хэмжээ нь 2018 оны 08 сарын судалгаагаар 4.49-259.2NTU, 2019 оны 05 сард нүүрсний уурхайн шүүрэл болон хаврын шар усны үер зэргээс шалтгаалан булингарын хэмжээ нэмэгдсэн 2018 оны үр дүнтэй харьцуулахад бага, харин 2019 оны 10 сард хур тунадас багасаж, алтны уурхайн үйл ажиллагаа зогссон зэргээс булингарын хэмжээ багассан дүр зураг харагдаж байна.

2019 оны 5 сарын судалгаагаар нүүрсний уурхайн шүүрлийн булингартай /462.7 NTU/ ус (лабориторид жингийн аргаар нарийвчлан судлахад умбуур бодис 1348 мг/л) Шарын голд нийлж байв. Шарын голд нүүрсний уурхайн шүүрлийн ус нийлэхийн өмнө голын усны булингар 11.97 NTU буюу ГУЦЗАН-той харьцуулахад “цэвэр”- ангилалд багтаж байсан. Харин уурхайн шүүрлийн ус нийлсний дараах цэг буюу SHR-4 цэгт булингарын хэмжээ 137.83 NTU болсныг ГУЦЗАН-той харьцуулахад “цэвэр” ангиллаас 5 дахин их, “маш их бохирдолттой” ангилалд орж байна. 2018 оны 08 сарын судалгааны үед хур бороо элбэгтэй байсан нь голын усны чанарт тодорхой хэмжээгээр нөлөөлсөн. Мөн 2018 онд Шарын гол төв замын гүүрнээс доош 200 метр орчим цэгт 24 цагийн хэмжилтээр булингарын хэмжээ 199.9-256.4 NTU хооронд гарсныг ГУЦЗАН-ны “цэвэр” ангилалтай харьцуулахад 8-12.5 дахин их, буюу “маш их бохирдолттой” ангиллаас 2 дахин их байна. Умбуур бодис буюу булингарын хэмжээ их илрэлттэй байгаа нь Шарын гол нь бүх хэсэгтээ хүний үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн байгаа нь харагдаж байна.

Усны нөөц, ус ашиглалтын салбарын ЭШДА Б.Саранчимэг